



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/012-НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Миндүг аудит ХХК-ийн

Аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: info@mindug.mn

Гүйцэтгэх захирал: С.Энхтөр

Утас: 95957791 Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>7</b>
<b>3.1 Албан шаардлага .....</b>	<b>7</b>
<b>3.4 Зөвлөмж .....</b>	<b>7</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>9</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.03.17 № 296

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоолоор 2024 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан бөгөөд нийт орлогыг 9,739.3 сая төгрөг, нийт зардлыг 11,008.3 сая төгрөг, алдагдлыг 1,269.0 сая төгрөг байхаар тогтоосон. Гүйцэтгэлээр 10,218.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11,861.2 сая төгрөгийн зардал гарсан нь нийт 1,643.1 сая төгрөгийн алдагдал үүсгэж, өмнөх оноос 49, төлөвлөсөнөөс 29 хувиар өссөн байна.

### Аудитын гол асуудал

Дөрвөлж ОНӨААТҮГ -ын өмнөх оны аудитаар өгсөн олон жилийн насжилттай айл өрх, аж ахуйн нэгжийн авлагыг барагдуулах ажил удааширалтай байгаа нь байгууллагын санхүүгийн төлөвлөлтөд сөрөг нөлөөлөл үүсгэж, зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрсдэл үүсэх магадлалтай байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл ажиглагдсангүй. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

МӨРИЙН ДУГААР	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,202,590,922.62	265,686,038.06
1.1.2	Дансны авлага	645,594,403.98	643,603,778.21
1.1.4	Бусад авлага	2,073,298.94	7,535,949.41
1.1.6	Бараа материал	311,697,278.90	398,750,968.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,470,709.34	139,743,709.14
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,166,426,613.78</b>	<b>1,455,320,443.47</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,376,528,372.56	10,795,461,229.51
1.2.2	Биет бус хөрөнгө	1,280,689,409.76	1,284,399,392.21
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>12,657,217,782.32</b>	<b>12,079,860,621.72</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,823,644,396.10</b>	<b>13,535,181,065.19</b>
2.1.1.1	Дансны өглөг	22,562,601.60	21,473,226.36
2.1.1.3	Татварын өр	61,230,617.06	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	13,692,909.02	11,826,897.66
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,818,606.69	2,810,037.49
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>99,304,734.37</b>	<b>36,110,161.51</b>
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,573,000,000.00	1,341,000,000.00
2.1.2.5	Хойшлогдсон орлого	3,614,602,598.55	4,022,781,713.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,187,602,598.55</b>	<b>5,363,781,713.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,286,907,332.92</b>	<b>5,399,891,874.51</b>
2.3.1	Өмч: - төрийн	17,891,641,028.25	17,891,641,028.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	236,955,957.55	236,955,957.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(8,591,859,922.62)	(9,993,307,795.12)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>9,536,737,063.18</b>	<b>8,135,289,190.68</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,823,644,396.10</b>	<b>13,535,181,065.19</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
<b>01</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>7,442,411,816.51</b>	<b>8,486,209,716.84</b>
02	Борлуулалтын өртөг	8,857,126,155.85	9,406,135,947.06
<b>03</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(1,414,714,339.34)</b>	<b>(-922,926,230.22)</b>
04	Түрээсийн орлого	25,954,545.25	35,058,269.52
05	Хүүний орлого	4,175,830.52	7,797,053.07
08	Бусад орлого	1,509,977,335.73	1,674,857,179.17
09	Борлуулалт, маркетингийн зардал	442,882,272.80	637,061,381.26
10	Ерөнхий ба удирдлагын зардал	514,490,161.42	579,727,100.84
12	Бусад зардал	134,955,941.83	1,235,967,037.64
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(133,346,548.44)	14,171,927.70
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(1,100,281,552.33)</b>	<b>(1,643,797,320.50)</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1,100,281,552.33)</b>	<b>(1,643,797,320.50)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(1,100,281,552.33)</b>	<b>(1,643,797,320.50)</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1,100,281,552.33)</b>	<b>(1,643,797,320.50)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>(1,100,281,552.33)</b>	<b>(1,643,797,320.50)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үе
1.1	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	<b>9,650,723,834.06</b>	<b>10,440,179,175.59</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,838,511,598.54	9,098,319,858.99
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,082,326.00	6,702,849.00
	Татаас санхүүжилтийн орлого	-	897,568,500.00
	Бусад мөнгөн орлого	1,807,129,909.52	437,587,967.60
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>	<b>8,724,708,500.53</b>	<b>10,988,168,625.77</b>
	Ажиллагчдад төлсөн	2,925,794,155.78	4,045,480,370.16
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	873,443,829.85	1,141,356,295.17
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,101,067,832.95	2,151,449,121.85
	Ашиглалтын зардалд төлсөн	951,053,730.00	955,102,139.47
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	591,202,964.72	794,358,306.27
	Татварын байгуулагад төлсөн	871,333,178.75	1,430,321,785.35
	Даатгалын төлбөрт төлсөн	1,601,385.00	10,049,850.00
	Бусад мөнгөн зарлага	409,211,423.48	500,718,196.98
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>926,015,333.53</b>	<b>(586,656,889.65)</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	493,163,742.89	350,247,994.91
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	493,163,742.89	350,247,994.91
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(493,163,742.89)</b>	<b>(350,247,994.91)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>432,851,590.64</b>	<b>(936,904,884.56)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>769,739,331.98</b>	<b>1,202,590,922.62</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,202,590,922.62</b>	<b>265,686,038.06</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>17,891,641,028.25</b>	<b>236,955,957.55</b>	<b>-5,542,511,226.49</b>	<b>12,586,085,759.31</b>
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-1,949,067,143.80	-1,949,067,143.80
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-1,100,281,552.33	-1,100,281,552.33
1	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>17,891,641,028.25</b>	<b>236,955,957.55</b>	<b>-8,591,859,922.62</b>	<b>9,536,737,063.18</b>
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	242,349,448.00	242,349,448.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-1,643,797,320.50	-1,643,797,320.50
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,891,641,028.25	236,955,957.55	-9,993,307,795.12	8,135,289,190.68

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 123.3 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 123.3 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн. Илрүүлсэн 123.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

##### 1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагаас авах нийт **123.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлэн баталгаажуулаагүй, гэрээний дагуу дансанд төвлөрүүлээгүй** нь авлагын бодит байдлыг бүртгэлд үнэн зөв тусгах, гүйлгээний бодит хэрэгжилтийг нотлох боломжгүй болгож байна. Энэ нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3, 20.2.6-д** заасан жинхэнэ хэрэгжилтийн зарчим болон тооцоо баталгаажуулах, баримтжуулах үүргийг зөрчсөн бөгөөд байгууллагын авлага барагдуулах үйл явц удаашрах, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах эрсдэлийг дагуулж байна.

##### 2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 361 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь үндсэн хөрөнгийн эдийн засгийн насжилт буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан (Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана) заалтыг мөрдөж ажиллах заалтуудад нийцэхгүй байна.

##### 3. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэр, орлого зарлагын 153 мэдээллээс 13 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан (Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам)-ын заалтыг хэрэгжүүлэх заалтыг зөрчсөн байна.

**Эдгээр давтагдсан болон хуулийн хэрэгжилтийг хангаагүй зөрчилд зөрчил дутагдлыг арилгах албан шаардлага хүргүүлээ.**

#### 3.4 Зөвлөмж

##### 1. Илрүүлэлт:

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нөөцөд байх шаардлагатай хэмжээнээс **хэтрүүлэн бараа, материалыг нөөцөлж хадгалсан** нь тухайн хөрөнгө **нэг жилийн дотор эргэлтэнд орохгүй байх нөхцөл** бүрдүүлж, компанийн **санхүүгийн тайлан дахь эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг хиймлээр нэмэгдүүлэх**, хөрөнгийн **ашиглалтын эргэлтийг удаашруулах** сөрөг үр дагавартай байна. Энэ нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-т** заасан жинхэнэ хэрэгжилтийн зарчимд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн бодит байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

#### **Өгсөн зөвлөмж:**

Бараа, материалын нөөцлөлтийг хэрэгцээ, эргэлт, ашиглалтад үндэслэн төлөвлөж, бодит хэрэгцээнээс хэтрүүлэхгүйгээр худалдан авалт хийх, хадгалалтын хяналтыг сайжруулах, мөн илүү бэлтгэгдсэн бараа материалын хадгалах хугацаа, хэрэглэгдэх стандарт, мөн бараа материалын хэвийн хорогдлоос сэргийлэх

#### **2. Илрүүлэлт:**

Борлуулалт болон зардлын анхан шатны баримтуудыг цахим төлбөрийн баримтаар бүрэн баталгаажуулаагүй нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2, 17.6-д** заасан анхан шатны баримтын **үнэн зөв байдал, иж бүрэн байдлыг хангах, татвар төлөгчийн эрх, үүргийг биелүүлэх** шаардлагыг зөрчиж, санхүүгийн тайлангийн бодит, хуульд нийцсэн байдалд сөргөөр нөлөөлсөн байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Борлуулалт болон зардлын бүх гүйлгээнд цахим төлбөрийн баримтыг тухай бүр **НӨАТ-ын хууль, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүрдүүлж, баталгаажуулан, тайлангийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хангаж ажиллах**

#### **3. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайлангийн зорилгоор тооцож, тусгасан боловч **ААНОАТ-ын зөрүүгийн тайланд** тусгаагүй нь **Татварын эрсдэл үүсэх** бөгөөд, **НӨАТ-ын хууль-ийн 17.1, 17.11-д** заасан элэгдэл, хорогдлын шимтгэлийг **баталгаажуулах, мэдэгдэл хүргүүлэх** үүрэг зөрчигдсөн байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайлангийн зорилгоор тооцож, **ААНОАТ-ийн зөрүүгийн тайланд** зөвхөн тухайн онд биш, бүх шаардлагатай үед **баталгаажуулж, тусгах замаар татварын эрсдлийг бууруулах**

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн.	1						1					
Анхны өртгөө бүрэн нөхсөн 361 ширхэг 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.	1				1							
123.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй	1	123.3			1	123.3						
Дүн	3	123.3			2	123.3	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн данс 13 мэдээ хоцроосон	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
АШБ цахимаар бүрэн баталгаажаагүй	1							1
ААНОАТ-ын тайланд элэгдлийн зардлын зөрүүг тусгаагүй	1							1
Дүн	2							2
Нийт дүн	3						1	2